



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 11 сарын 27-адар

Дугаар A/516

Мандалговь

Г Бичил уурхай эрхлэгчдээс
жонш худалдан авах аж ахуйн нэгж
сонгох тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 70 дугаар тогтоолоор баталсан "Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах журам"-ын 5.1 дэх заалт, "Ажлын хэсэг томилох тухай" аймгийн Засаг даргын 2018.09.05-ны А/369 дугаар захирамжийн 2 дахь заалт, уг захирамжаар томилогдсон ажлын хэсгийн 2018.11.16-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Баянжаргалан сумын бичил уурхай эрхлэгчдээс жонш худалдан авах аж ахуйн нэгжээр "Говь Аргатай девелопмент" ХХК, "Ембүүт хэрлэн энэрgeo" ХХК, "Айраг эксплорэйшн" ХХК"-үүдиг сонгон шалгаруулж ажиллуулсугай.

Хоёр. Сумын Засаг дарга, худалдан авалт хийхээр сонгогдсон аж ахуйн нэгж, бичил уурхай эрхлэгчдийн хооронд гурвалсан гэрээ байгуулж ажиллахыг Баянжаргалан сумын Засаг дарга (Г.Туяа), бичил уурхай эрхлэгч нэхэрлэлийн ахлагч, аж ахуйн нэгжийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

Гурав. Бичил уурхайн болон худалдан авалтын үйл ажиллагаа хууль тогтоомжийн дагуу явагдаж байгаад байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар (Ш.Тербат), Баянжаргалан сумын Засаг дарга (Г.Туяа), холбогдох хууль, хяналт, мэргэжлийн байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О БАТ-ЭРДЭНЭ



488010596